



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/233

Улаанбаатар хот

**“Дулаан Багахангай” аян зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, албан байгууллагууд, нийтийн орон сууц, гэр хорооллын айл өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, дулаан хэмнэлтийн зөв дадалд бүх нийтийг уриалах зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 03-ний өдрөөс 11 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд “Дулаан Багахангай” аяныг зохион байгуулахыг дүүргийн Менежер (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

2. Аяныг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус аяныг зохион байгуулахад зарцуулагдах 1,250,000 (нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр мэдээлж, иргэд, олон нийтэд сурталчлахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2025 он ажил\захирамж

1225010888

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 23-ны өдрийн 1223 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт




АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:
Гишүүд:

Г.Дагвадорж	Дүүргийн менежер
Д.Хүрэлбаатар	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Д.Гантулга	Илч-Орд ОНӨААТҮГ-ын захирал
Б.Дуламсүрэн	Хэсгийн зуухны мастер
Д.Бужигдай	"Хангай өргөө" Сууц өмчлөгчдийн холбооны захирал
Л.Алтантөгс	"Баян хангай" Сууц өмчлөгчдийн холбооны захирал
З.Нармандах	"Их хангай" Сууц өмчлөгчдийн холбооны захирал
Нарийн бичиг: Б.Дүүрэнжаргал	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 03-ны өдрийн 402 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



“ДУЛААН БАГАХАНГАЙ” АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1.	“Дулаан Багахангай” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулах, аж ахуйн нэгж байгууллага, хороодод хүргэх.	2025.11.04	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
2.	Орон сууцны болон гэр хорооллын айл өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэл хангасан эсэх талаарх судалгаа гаргах.	2025.11.03 2025.11.08	ХСТНААХ Хороод
3.	Аяны хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн орон сууц, гэр хорооллын өрхүүдийн орон байрыг дулаалуулах арга хэмжээ зохион байгуулах	2025.11.08 2025.11.28	ЗДТГ Хороод Бүх аж ахуйн нэгж байгууллагууд
4.	Орон сууцны байрнуудын орцны хаалга, цонхыг дулаалах, подвалын цонхнуудыг битүүлэх	2025.11.07 2025.11.15	“Хангай Өргөө” СӨХ “Их Хангай” СӨХ “Баян хангай” СӨХ
5.	Аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтан, албан хаагчдынхаа тодорхой хэсэгт, нүүрс, түлээний дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх	2025.11.03 2025.11.28	Бүх аж ахуй нэгж, байгууллагууд,
6.	Дүүргийн дэмжлэг, тусламж зайлшгүй шаарлагатай айл өрхөд, түлээ, нүүрсний туслалцаа үзүүлэх	2025.11.03 2025.11.28	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс Хороод
7.	Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, дүн мэдээг нэгтгэх	2025.12.05	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 03-ны өдрийн 1033 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



“ДУЛААН БАГАХАНГАЙ” АЯНД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Санал
					Нийт үнэ
1	Нүүрс	тн	10	125,000	1,250,000
			Дүн		1,250,000

